

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/323/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ХАЛАМЖИЙН САНГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.10 № 01/39
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХАЛАМЖИЙН
САНГИЙН ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан нь Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа Цахим Монгол хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг нэвтрүүлсэн байна.

Сангийн яам, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам болон Гааль, Татвар Санхүүгийн Мэдээллийн Технологийн Төвтэй хамтран ehalamj.mn цахим системийг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн мөнгө Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь дансанд шууд ордог болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторовн мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,432.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 мянган төгрөг болж 2,432.0 мянган төгрөгөөр буурсан нь Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь дансанд шууд ордог болсон байна.

- Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг нэвтрүүлснээр нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн санхүүжилт 2022 оны 2 сараас олгоогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	2,432,000.00	
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]	2,432,000.00	0
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө/Улсын төсөв/	2,432,000.00	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	2,432,000.00	0
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	2,432,000.00	0
41	Богино хугацаат өр төлбөр [18]+[21]+[22]+[23]	736,170.00	0
4.1	Өглөг [18]+[21]+[22]+[23]	736,170.00	0
410301	Хувь хүнд өгөх улсын төсвийн өглөг	736,170.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [16]+[24]	736,170.00	0
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]	736,170.00	0
510301	Өмнөх үеийн үр дүн	4,800,285.70	1695830.00
510302	Тайлант үеийн үр дүн	-3,104,455.70	-1695830.00
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	1,695,830.00	0.00
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	2,432,000.00	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	4,672,266,700.00	89,792,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтын орлого	4,672,266,700.00	89,792,000.00
14	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]	97,886.94	0
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	97,886.94	0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	4,672,364,586.94	89,792,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [11]+[12]+[13]+[14]	0	91,487,830.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	100,074,816.64	7,636,810.00
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	100,074,816.64	7,636,810.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [40]-р мөр	4,574,224,526.00	91.00
2701010101	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	1,313,923,130.00	0
2701010102	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	1,056,028,120.00	0
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	777,240,460.00	0
2701021300	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	74,400.00	0
2701010900	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	332,232,316.00	11,143,900.00
2701010105	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	0.00	7,853,220.00
2701021701	Боловсролыг дэмжих үйлчилгээ	160,408,500.00	0
2701010106	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	906,064,000.00	64,792,000.00
2701010108	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	21,848,000.00	0
.	Банкны шимтгэл [41]+[45]	1,169,700.00	
.	Банкны шимтгэл УТ [42]+[43]+[44].+[56]	1,169,700.00	61,900.00
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	1,169,700.00	61,900.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	4,521,603,334.91	83,851,020.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	150,761,252.03	-1,695,830.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	13,024,294,590.00	89,792,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтын орлого	12,872,594,590.00	89,792,000.00
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	10,035,862.81	0
1401013	Улсын төсвийн буцаасан орлого	11,662,430.00	0
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	0.00	89,853,900.00
210	БАРАА,АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [13]+[14]+[15]+[16]	0	89,792,000.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[78]	4,468,943,851.00	84,587,190.00
2701021100	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	1,314,295,630.00	0
2701021200	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	1,061,739,080.00	0
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	772,980,460.00	0
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	258,098,091.00	11,143,900.00
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	134,832,990.00	7,991,290.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	906,064,000.00	64,792,000.00
2702020308	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	20,933,600.00	0
.	Банкны шимтгэл [40]+[44]	1,169,700.00	61,900.00
.	Банкны шимтгэл УТ [41]+[42]+[43]	1,169,700.00	61,900.00
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	1,169,700.00	61,900.00
.	Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт [50]+[51]	1,335,320.00	0
4103011	Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт УТ	1,335,320.00	0
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	26,276,108.91	7,636,810.00
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	26,276,108.91	7,636,810.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64]	4,497,724,979.91	92,224,000.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [11]-[56]	178,688,217.03	-2,432,000.00
.	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [60]-[59]	0	2,432,000.00
.	Мөнгө, түүнтэй өдилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,432,000.00	2,432,000.00
.	Мөнгө, түүнтэй өдилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,432,000.00	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний	Хуримтлагдс үр дүн	Засгийн хувь нийт дүн
1	2021 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	37,525,364.26	37,525,364.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	0	0	0	0
7	Тайлант үеийн үр дүн	0	0	-32,725,078.56	-32,725,078.56
8	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	4,800,285.70	1,695,830.00
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0	0	0	0
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0	0	0	0
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	0	0	0	0
14	Тайлант үеийн үр дүн	0	0	-3,104,455.70	-3,104,455.70
15	2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	1,695,830.00	1,695,830.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/төгрөгөөр/	
	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	2,432,000.00
2	Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]+[13]+[14]+[15]+[16]+[17] +[18]+[19]+[20]	89,792,000.00	83,989,090.00
3	Алдарт эхийн одонгийн мөнгө	0	0
4	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тэтгэмж тусламж, хөнгөлөлт	0	0
5	Насны хишиг	0	0
6	Халамжийн сан	0	0
7	Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж	0	0
8	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	0	0
9	Хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрийн зардал	0	0
10	Банкны шитмгэл	-	61,900.00
11	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	0	0
12	Өрх толгойлсон эх,эцэг хөтөлбөрийн зардал	0	0
13	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	15,000,000.00	11,143,900.00
14	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт		0
15	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт		0
16	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт		0
17	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	10,000,000.00	8,589,390.00
18	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	64,792,000.00	64,792,000.00
19	Ихэр хүүхдийн тэтгэмжийн зарцуулалт		0
20	Иргэн бүрт олгох 300 зарцуулалт		0
21	Сангийн үйл ажиллагааны зардалын дүн		0
22	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	89,792,000.00	89,792,000.00
23	Тохируулгын дүн [1]+[11]-[2]-[15]	0	0.00
24	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан нь халамжийн сангийн хэлтсийн дарга, нийгмийн халамжийн сангийн мэргэжилтэн, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн судалгаа, өргөдөл гомдол, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа, хүүхдийн мөнгө хариуцсан мэргэжилтэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, зорилтот бүлгийн хүн ам өрхийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэсэн 5 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан нь нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламж дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэдэд хууль тогтоомж, бодлого шийдвэр, журмын дагуу хүргэх зорилт тавин ажилласан байна.

Тус газар нь тайлант онд нийгмийн халамжийн үйлчилгээний талаар тусгагдсан зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн 94,1 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 04 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Дотоод хяналтын нэгж томилох тухай" А/65 тушаалаар шинэчлэн томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/158 тоот тушаалаар "Дотоод хяналт зохион байгуулалтын журам" боловсруулан баталж, мөрдөн ажилласан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь нийгмийн халамжийн сангийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний Ehalamj программын олголтод дотоод хяналт хийх календарьчилсан төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 26 суманд хийж 583 ахмад настны асаргаа, 197 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа, 198 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжийн хувийн хэргүүдийн анхан шатны баримтын бүрдэлт, цахим бүртгэл, Ehalamj программын олголт, мэдээлэлтэй тулгаж, зөвлөмж өгч хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн хэмжээнд 2022 онд 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгох мөнгөн тэтгэмж үйлчилгээнд 34,118 хүүхэд хамрагдаж 40,714,000.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас хүүхэд бүрийн

дансанд шууд олгосон байна. Үүнээс эцэг, эх, асран хамгаалагч хүүхдийн эрхийг зөрчсөн, тэжээн тэтгэх үүргээ үл биелүүлсэн талаар Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн газрын хүүхдийн эрхийн улсын байцаагч дүгнэлт гарган зогсоосон 17 өргөдөл хүлээн авч, 29 хүүхдийн 87 сарын 8,700.0 мянган төгрөгийг зогсоосон байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2022 оны ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №А/289 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Халамжийн сангийн бүртгэл тайлагналын бүртгэлийн үйл ажиллагааг 4 бүлэгт тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,432.0 мянган төгрөгөөр буюу 100 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,432.0	0	-2,432.0
Авлага			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	2,432.0	0	-2,432.0
Өр төлбөр	736.2	0	-736.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,695.8		-1,695.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,432.0	0	-2,432.0

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,432.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 мянган төгрөг болж 2,432.0 мянган төгрөгөөр буурсан нь Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг нэвтрүүлж нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн мөнгө Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь дансанд шууд ордог болсонтой холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 24,325,401.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 22,663,661.7 мянган төгрөгөөр бууруулан ирүүлсэн байна. Энэ нь 2020 оны 9 дүгээр сараас халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж байгаагаас 72 үйлчилгээ тус бүрээр хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 69 арга хэмжээг хасч, 3 арга хэмжээ буюу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнс тэжээлийн дэмжлэгийн үйлчилгээнд зарцуулах төсөв батлагдаж ирсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөтөлбөрийн 240,000.0 мянган төгрөг, ахмад настанд олгох хөнгөлөлт тусламж үйлчилгээний 673,740.0 мянган төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 748,000.0 мянган төгрөг, 1,661,740.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр батлан ирүүлсэн байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд төсвийн санхүүжилтийг тайлант оны 1 дүгээр сард 3 арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр 89,792.0 мянган төгрөгөөр олгож, ehalamj.mn цахим системийг бүрэн нэвтэрснээр мөн оны 2 дугаар сараас улсын төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа Цахим Монгол хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг нэвтрүүлсэн байна.

Сангийн яам, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам болон Гааль, Татвар Санхүүгийн Мэдээллийн Технологийн Төв хамтран ehalamj.mn цахим системийг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн мөнгө Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь дансанд шууд уншигддаг болсон байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд гүйцэтгэлээр улсын төсвөөс 89,792.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх оны арилжааны банкин дахь үлдэгдэл 2,432.0 мянган төгрөг, төсвийн үлдэгдэл 5,266.7 мянган төгрөг нийт 7,636.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 84,525.3 мянган төгрөг буюу 94,1 хувьтай байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөтөлбөр зардлын төсвийг 1,410.6 мянган төгрөгөөр, ахмад настанд олгох хөнгөлөлт тусламж үйлчилгээний зардлын төсвийг 3,856.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Орон нутгийн төсвөөс 151,139.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 63,600.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 6,985.0 мянган төгрөг, нийт 70,585.0 мянган төгрөгийн зарцуулж 80,554.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 70,585.0 мянган төгрөг буюу 46,7 хувьтай байгаа нь жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон зардлын төсвийг 37,000.0 мянган төгрөгөөр, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлын төсвийг 43,554.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс					
1	хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөтөлбөр	10,000.0	8,589.4	1,410.6	85,9%
2	ахмад настанд олгох хөнгөлөлт тусламж үйлчилгээний	15,000.0	11,143.9	3,856.1	74,3%
3	хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	64,792.0	64,792.0	0	100%
	Дүн	89,792.0	84,525.3	5,266.7	94,1%
Орон нутгийн төсвөөс					
1	71902-80709	100,600.4	63,600.0	37,000.0	63,2%
2	71902-80708	50,539.4	6,985.0	43,554.4	13,8%
	Дүн	151,139.4	70,585.0	80,554.4	46,7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэл байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд улсын төсвөөс 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ, орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Улсын төсөв: Нийгмийн халамжийн үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Нийгмийн халамжийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын хэрэгжилтийг хангах, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид шинээр хамрагдсан болон сунгуулсан иргэдийн мөнгийг програмын түвшинд хянан баталгаажуулж олгох	НХСангийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн олголтын хэрэгжилт 91,1%	89,792.0	84,525.3
2	Орон нутгийн төсөв: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2022.01.01 2022.12.31	Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрх, өрхийн гишүүн- иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, төсөлд хамруулах,	НХСангийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн олголтын хэрэгжилт 46,7%	151,139.4	70,585.0

			амьдрах ухаанд сургахад чиглэгдэнэ.			
--	--	--	-------------------------------------	--	--	--

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн олголт хөтөлбөрын хэрэгжилт 46,7%-тай байна.Үүнд:

1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ тайлант онд нийт 53 өрхийн 56 гишүүн сайн дурын үндсэн дээр бүлэг болон нэгдэж, 26 төсөл ирүүлснээс төслийн шаардлага хангаагүй, бүлэг болон нэгдэж чадаагүй, хэрэгжүүлэх төслийн үр дүн тооцоолол байхгүй, цаашид хийх үйл ажиллагаа тодорхойгүй, төсөл хамгаалах ажлын хэсгийн хуралд оролцохоос бүлгийн гишүүд татгалзсан, хуралд оролцоогүй гэх зэрэг шалтгааны улмаас төслүүд хасагдаж, 4 бүлгийн төсөл шалгарч санхүүгийн дэмжлэг авснаас шалтгаалсан байна.

2.Орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж нь гэнэтийн аюул ослоос болж гэр оронгүй болсон, амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх, иргэнд, хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэнд, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд олгогддог учраас тайлант онд хүсэлт гаргасан 53 иргэнд олгосон байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2022 оны 89,792.0 мянган төгрөгийн нийт батлагдсан төсвийн зардлаас 1,5 хувиар буюу 1,346.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,010.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 96.8%-тай, 5,0 саяас дээших орлогын 15 гүйлгээ байршуулж, үүнээс 2 орлогын гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар гарсан алдаа зөрчил байхгүй байна.

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn